

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5 – 25

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09-01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

5 – 25

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 11-ний өдөр /Мягмар гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 54.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, О.Номинчимэг, О.Саранчулуун, Р.Сэддорж, А.Ундраа, С.Цэнгүүн;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Х.Булгантуяа, Т.Мөнхсайхан, М.Нарантуяа-Нара, Н.Номтойбаяр, Г.Хосбаяр, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батлут, Б.Баярбаатар, Л.Гантөмөр, С.Лүндэг, Л.Мөнхбаатар, П.Мөнхтулга, Ч.Номин, Х.Тэмүүжин, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Ч.Анар, Х.Баттулга, Б.Батцэцэг, Х.Болормаа, Ц.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, П.Сайнзориг, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан – 12 минут, О.Амгаланбаатар – 45 минут, Т.Аубакир – 14 минут, Э.Бат-Амгалан – 07 минут, Б.Батбаатар – 37 минут, Ж.Батжаргал – 02 минут, Ж.Батсуурь – 12 минут, Д.Ганбат – 47 минут, Б.Дэлгэрсайхан – 29 минут, Б.Жавхлан – 10 минут, Д.Жаргалсайхан – 04 минут, Ч.Лодойсамбуу – 05 минут, М.Мандхай – 04 минут, Г.Очирбат – 04 минут, Ц.Туваан – 45 минут, Б.Тулга – 08 минут, Г.Тэмүүлэн – 24 минут, Н.Учрал – 09 минут, Да.Цогтбаатар – 04 минут, Д.Цогтбаатар – 02 минут, Б.Чойжилсүрэн – 15 минут, Ж.Энхбаяр – 09 минут, М.Энхцэцэг – 05 минут, Р.Эрдэнэбүрэн – 31 минут.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09-01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Төгсжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Гангэрэл, Р.Ринчинбазар, А.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Б.Бейсен, С.Эрдэнэбат, С.Одонтуяа, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ТӨСВИЙН БОЛОН
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНААС
ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын
дэмжсэн санал:**

Б.Пүрэвдорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Р.Сэддорж нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд “31,600.0 тэрбум төгрөг” гэснийг “31,930.0 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь 2026 онд “30.9” гэснийг “31.2” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл “-1,380.0 тэрбум төгрөг” гэснийг “1,050.0 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь 2026 онд “-1.3” гэснийг “-1.0” гэж, Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 2026 онд “29,552.0 тэрбум төгрөг” гэснийг “29,859.1 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “28.9” гэснийг “29.2” гэж, Нэгдсэн төсвийн суурь тэнцэл “2,048.0 тэрбум төгрөг” гэснийг “2,070.9 тэрбум төгрөг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 32
Бүгд: 93
65.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын
дэмжээгүй санал:**

Б.Пүрэвдорж: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд “31,600.0 тэрбум төгрөг” гэснийг “490.0 тэрбум төгрөг”-өөр, Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд “32,980.0 тэрбум төгрөг” гэснийг “490.0 тэрбум төгрөг”-өөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах ДНБ-д эзлэх хувьд өөрчлөлт оруулах гэсэн Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 40
Бүгд: 93
57.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 57 минутад хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 50 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 93 гишүүн ирж, 73.8 хувийн ирцтэйгээр 14 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
14 цаг 08 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Ирц 126-аас 68 гишүүн ирсэн байна. Яг одоогоор Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороо хуралдаж байгаа учраас Байнгын хорооны гишүүд орж ирж ирцдээ орохыг хүсэж байна.

Ирц 54 хувь хүрсэн тул энэ өдрийн чуулганыг эхлүүлье.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах нэг асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулна.

Засгийн газар 2025 оны 9 сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлэг тодорхой асуудлын хүрээнд явна. Зарчмын зөрүүтэй 2 саналтай.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хоёр бүлгийн даргаар дамжуулан болон зөвлөлөөр дамжуулан аливаа нэгэн горимын санал ирээгүй. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2025.09-01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг/**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулна.

Төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа явуулж нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусгасан төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31.6 их наяд төгрөг гэснийг 490.0 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд 32.98 их наяд төгрөг гэснийг 490.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувьд өөрчлөлт оруулах гэсэн саналд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон төсвийн тусгай шаардлагад нөлөөлөхөөр байна гэж дүгнэсэн.

Уг дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1.5 дахь заалтын дагуу Байнгын хороодын хамтарсан хуралдаанд багш нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбогдуулан 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд холбогдох өөрчлөлтийг хийх талаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан саналтай холбогдсон тооцооллыг дахин нягтлах чиглэл өгч төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар буцаасан.

Байнгын хороод 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хамтарсан хуралдаанаар хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т заасны дагуу явуулсан бөгөөд уг хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Д.Үүрийнтуяа нар Улсын Их Хурлаар Төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцэхэд холбогдох хуульд нийцээгүй хууль зөрчсөн саналуудаар санал хураалт явуулахгүй байхад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн

Б.Мөнхсоёл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн зардлуудыг нэмж болохгүйг сануулж, зардал нэмүүлэх саналыг эх үүсвэртэй нь уялдуулан гаргадаг байх, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа цалин тэтгэвэр нэмэгдүүлж байгаатай холбогдуулан инфляц өсөж болзошгүй учраас Монголбанк Эдийн засаг, хөгжлийн яамнаас инфляцыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан Улсын Их Хурлаар дунд хугацааны төсвийн төсөөллийг хэлэлцүүлэхгүй зөвхөн тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэн баталдаг байх нь зүйтэй талаар үг хэллээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгээр багш, эмч, эмнэлгийн ажиллагсад, төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагын ажилчдын цалин болон тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх асуудал шийдэгдэхээр болсонтой холбогдуулан төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд холбогдох өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй гэсэн санал гаргасныг Байнгын хороодын хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Б.Мөнхсоёл гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд. Сайдыг дуудъя. Б.Жавхлан сайдыг бас дуудаарай. Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ринчинбазар, Амаржаргалын Энхбат нар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Баярсайханы Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал, Цэрэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,

Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга ирсэн байна.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү?

Д.Бум-Очир гишүүнээр тасаллаа. Н.Учрал сайдыг дуудъя.

Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Бум-Очир: Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 99 компани, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 472 хуулийн этгээд байдаг гэсэн ийм тоон мэдээлэл байна.

Бид бүгдээрээ ярьж байгаа. Маш олон гишүүд ярьсан. Энэ төрийн өмчит компаниудыг, орон нутгийн өмчит компаниудыг, өмчийн оролцоотой компаниудыг ер нь яах юм бэ гэдэг асуудлууд.

Хамгийн ноцтой асуудал юу вэ гэхээр эдгээр компаниуд маань ашиггүй ажиллаад байж байгаа. Энэ асуудлыг цэгцлэхээр хуулийн төсөл өргөн барьсан юм байна гэж ойлгосон.

Энэ хуулийн төслийн судалгаанаас харах юм бол эдгээр компаниуд нь –

- засаглал нь тодорхойгүй,
- эрх зүйн зохицуулалт нь тодорхойгүй,
- ногдол ашиг хуваарилах зарчим нь тодорхойгүй,
- хувьцаа эзэмшигч төр, иргэд, ард түмэн эрхээ хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй,
- хуулийн этгээдийн хэлбэрийн, зөрчилтэй улс төрийн томилгоо хийгддэг,
- санхүүгийн сахилга батгүй,
- үр ашиггүй зардал гаргадаг,
- хариуцлага хүлээдэггүй,
- ашиггүй ажилладаг,
- алдагдалд ордог.

Тэгээд цаашлаад ард түмний мөнгөөр, нарийн ярих юм бол –

- ▶ татвар төлөгчдийн мөнгөөр тэжээгдээд байж байдаг,
- ▶ бизнес төлөвлөгөө нь биелдэггүй,
- ▶ хөндлөнгийн хяналт хийгддэггүй,
- ▶ ил тод биш -

гэхчлэнгийн маш олон янзын асуудлууд байна.

2023 оны байдлаар –

- ▶ 23 их наяд 617.0 тэрбум төгрөгийн орлого олсон.
- ▶ 16 их наяд 912 тэрбум төгрөгийн зарцуулалттай байсан байна.

2024 онд ямар тоо байгааг нь сонсмоор байх юм.

Хамгийн гол нь миний хэлэх гээд байгаа гол зүйл бол юу вэ гэхээр улсын төсөв 30 хэдэн их наяд гэж ярьж байгаа бол энд 17 орчим их наядын буюу улсын төсөвтэй бараг тэнцэхүйц хэмжээний мөнгийг бид нарийн мэдээлэлгүйгээр байлгаад байгаа юм.

Өөрөөр хэлбэл бид улсын төсвөө багтааж ядаад байж байхад энд яаж байна вэ гэхээр улсын төсөвтэй дүйцэхүйц хэмжээний мөнгө үндсэндээ зарцуулагдаад байгаа юм.

Энэ зарцуулалтыг их тодорхой болгомоор байна.

Тэгээд энэ дээр Эдийн засаг, хөгжлийн сайд хариулах болов уу гэж бодож байна. Миний ойлгож байгаагаар төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл 2025 оны нэг сард өргөн барьсан. D-Parliament дээр байгаад байгаа.

Энэ төрийн өмчит компаниуд ашиггүй ажиллаад байгааг цаашид сайжруулаад улсын төсөвтөө хэдий хэмжээний мөнгө хөрөнгийг эндээс татаж оруулж ирэх боломжтой юм бэ? Ялангуяа ирэх жилийн улсын төсөв дээр төрийн өмчит компаниуд энэ асуудлаа цэгцлээд улсын төсөв дээрээ нэмэр болох, улсын төсвөө тэлэх боломж байгаа эсэхийг тодруулмаар байгаа юм.

Тэгэхээр төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль хэзээ орж ирэх юм бэ? Засаг дээр гацаад байгаа юм уу? Их Хурал дээр гацаад байгаа юм уу?

Энэ хууль батлагдсанаар улсын төсөвт ямар хувь нэмэр оруулах нөхцөл бололцоо, улсын төсөв хэрхэн тэлэх нөхцөл бололцоо бүрдэх юм бэ гэдгийг тодруулмаар байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Сандагийн Бямбацогт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, сайд хариулна.

С.Бямбацогт: Төрийн өмчит компаниудын бодлого, зохицуулалттай холбоотой асуудал Ерөнхий сайдын харьяанд буюу Засгийг газрын Хэрэг эрхлэх газарт харьяалагддаг.

Тэгээд энэ хүрээндээ Таны асуултад хариулъя.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад –

- төрийн өмчит 104 компани үйл ажиллагаа явуулж байгаа. 60 орчим мянган хүн ажиллаж байгаа.
- Орон нутгийн өмчит 350 орчим мянган компани үйл ажиллагаа явуулж байна. 20 орчим мянган хүн ажиллаж байна.

Төрийн өмчит компаниуд та 2023 оны ашиг орлогын талаар ярьсан.

2024 онд ямархуу ашигтай ажилласан бэ гэдэг дээр Та мэдээлэл хүссэн.

2024 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит компаниуд нийтдээ 26 их наяд төгрөгийн одоо орлого олсон. 5.8 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.

Үүнийг 2023 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад орлогын хэмжээ 10.1 хувиар нэмэгдсэн. Ашгийн хэмжээ одоо 15 орчим хувиар буюу 746.0 тэрбум төгрөг нэмэгдсэн байгаа юм.

Өөрөөр хэлбэл төрийн өмчит компаниуд бүгдээрээ ашиггүй ажиллаж байгаа, бүгдээрээ их муу, муухай байгаад байгаа биш тодорхой хэмжээгээр сүүлийн жилүүдэд төрийн өмчит компаниудын орлого нэмэгдэж байна, ашиг нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор төсөвт төвлөрүүлж байгаа татвар, төлбөр, хураамж нэмэгдэж байгаа.

Нүүрс олборлодог компаниудыг хувийн өмчийн компани, төрийн өмчийн компаниуд харьцуулаад үзэхэд олборлож байгаа нүүрсний хэмжээ нь адилхан мөртөө улсын төсөвт төвлөрүүлж байгаа татвар, төлбөр, хураамж нь үндсэндээ төрийн өмчит компаниудынх хоёр дахин их байх жишээний.

Мөн Эрдэнэт үйлдвэрийг Оюу Толгойтой харьцуулаад үзэхэд олж байгаа орлого нь адилхан мөртөө төлж байгаа татвар нь үндсэндээ Оюу Толгойгоос гурав дахин их татвар, төлбөр хураамжийг Эрдэнэт үйлдвэр төлж байх жишээний. Иймэрхүү төрийн өмчит компаниуд дээр сайн жишээ байна. Муунууд нь ч бас байгаа.

Төрийн өмчит компаниудыг нэгдүгээрт нь нийгмийн хариуцлагын хүрээнд гарцаа байхгүй ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах энэ хүрээнд үйл ажиллагаа явуулдаг компаниудыг төр аваад явж байгаа. Үүнийг цаашдаа төр, хувийн хэвшлийн түншлэлээр явуулах бодлогоо барьж хэрэгжүүлэх.

Мөн хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй үйлчилгээнүүдийг хувьчлах, хувийн хэвшилд шилжүүлэх бодлогыг барих.

Яах аргагүй стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээ илүү ил тод, нээлттэй, хариуцлагатай болгох бодлогуудыг хийх ёстой.

Энэ хүрээндээ Улсын Их Хуралд Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль, Нийтийн өмчийн тухай гэсэн хоёр хуулийг өнгөрсөн хавар Их Хуралд өргөн барьсан. Их Хурал үүнийг яаралтай хэлэлцэж, яаралтай баталж өгөх юм бол энэ төрийн өмчит компаниуд холбоотой асуудал нэг мөр цэгцэрнэ ээ. Нэг мөр цэгцэрнэ.

Б.Пүрэвдорж: Дуламын Бум-Очир гишүүн нэмж тодруулъя.

Д.Бум-Очир: Их олон гишүүд асууж ярьж байгаа.

Хамгийн гол нь төрийн өмчит компаниудаа цэгцэлснээр улсын төсөвт ямар нөлөө үзүүлэх вэ гэдгийг л тодруулмаар байгаа юм. Тийм тооцоо хийгдсэн үү? Ялангуяа ирэх жилийн төсөв дээр бид төсвөө тэлэх шаардлагатай байгаа. Энэ олон цалин нэмэгдсэн байж байгаа.

Тэгэхээр ерөөсөө гол зүйл юу вэ гэхээр төрийн өмчит компаниудынхаа асуудлыг цэгцэлснээр. Бид зөндөө ярьж байгаа шүү дээ. Тэнд чинь хулгайч байна гэж ярьж байгаа, улс төрийн ч томилгоо хийгдээд байна гэж ярьж байгаа. Маш их хэмжээний мөнгө байгаа шүү дээ.

2023 оны байдлаар зарлага нь гэхэд 17 их наяд. Бид 30 их наядыг яриад сууж байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг цэгцэлснээр улсын төсөв дээр ямар нэгэн байдлаар хувь нэмэр оруулж ирэх үү? Улсын төсөв ингэснээр тэлэх магадлал боломжтой юу? Өөрөөр хэлбэл мөнгөө хэмнээд илүү үр ашигтай зүйлд зарцуулах боломж бидэнд олдох уу гэдгийг л тодруулга байна. Тийм тооцоолол хийсэн байдаг юм уу?

Б.Пүрэвдорж: Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Тийм.

Ер нь үе шаттай төрийн өмчит компаниудыг цэгцлэх, ялангуяа “Эрдэнэт үйлдвэр”, “Эрдэнэс Тавантолгой” гэсэн хоёр том компани л байгаа.

Стратегийн орд, үндэсний баялгийн санд орлого төвлөрүүлдэг, ногдол ашиг өгдөг үндсэндээ хоёр том саалийн үнээ.

Эрдэнэт үйлдвэрийн тухайд гэх юм бол гэрээний хулгайнуудыг бүгдийг нь таслан зогсоож байгаа. Овоолгын хулгай байсан таслан зогсоосон. Гэрээний хулгай байсан. Биржээр зэсийн баяжмалаар арилждаг болсон.

Дээрээс нь тендерийн худалдан авалт, шахааны бизнесийг ил тод хиймэл оюун ухаан ашигладаг болсон ийм сайн жишээнүүд гарч байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” дээр гэхэд өнөөдөр олон улсын аудит оруулж бүх үйл ажиллагаанд нь хяналт хийж байгаа.

Санхүүгийн гүйлгээнүүдийг, орлого зарлагуудыг нь, худалдан авах ажиллагааны бүх гэрээнүүдийг бүгдийг нь ил болгосон.

Цаашдаа ил тод, шилэн байх ажлуудыг хийж хэрэгжүүлснээрээ илүү олон түмний хяналтад орж, хулгай зэлгийг нь арилгах, илүү үр өгөөжтэй болох боломжууд бүрдэнэ ээ гэж... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сая Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороон дээр байсан гишүүд хоцорч орж ирсэн.

Асуулт асууж, үг хэлэх хүн байвал дахиж нэр авна шүү. Гараа өргөөд орж болно.

Буланы Бейсен гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Бейсен: Төсөвтэй холбоотой хэд хэдэн асуулт асууя гэж бодож байна.

Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалинг он гараад 15 хувь нэмнэ гэж байна. Уг нь эмч, багш нарын цалинг нэмэгдэх асуудлыг бид тавьсан л даа. Ядахдаа 50 хувь нэм гэдгийг. Боловсролын салбарынхныг 76 хувь нэмсэн.

Эрүүл мэндийн салбарт хуваарилж байгаа нь 15 хувь гээд 191.0 тэрбум л хуваарилсан шүү дээ.

Тэгэхээр энэ асуудал дээр түрүүн Хэрэг эрхлэх газрын дарга ярьж байсан. Эрүүл мэндийн даатгалын санд хулгай байна. Хулгайн асуудлыг шийдэж байж шийднэ гээд. Энэ нь хэзээ шийдэгдэх юм. Даатгалын сан хулгай хийсэн байвал хэчнээн тэрбум төгрөг орж ирнэ гэж Та тооцоолж байна. Энэ хэдийд яах юм? Эрүүл мэндийн салбар эм, эмнэлгийн хэрэгслийн дутагдалтай, эмч нар ажлын ачааллаас болоод зарим нь амь нас алдаж байна.

Нөгөө талаар улсын клиникийн эмнэлгүүд, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн өр зээл хэд байна? Он дамжсан жил жилд өр байж байх юм. Он гарсны дараа дахиад л залгаад яваад өгдөг.

Нөгөө талаар шинээр баригдаж байгаа сургууль, цэцэрлэгийн компьютер, тоног төхөөрөмж, эмнэлгүүдийн тоног төхөөрөмж байхгүй асуудлууд байж байна.

Ногооннуур суманд хоёр эмнэлэг баригдсан. Улаанчулуун баг, Ховд баг гээд. Үүний төсөв одоо хүртэл байхгүй. Эмнэлэг нь баригдсан. 2 жил болж байна. Ийм барилга нь баригдсан, дотроо тоног төхөөрөмж нь байхгүй. Үүнийг яаж шийдсэн юм. Улсын хэмжээнд энд гаргасан юм байна уу? Дараа нь тодруулъя.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? С.Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Эрүүл мэндийн даатгалын сан дээр бид хяналт шалгалт хийсэн.

Энэ хяналт шалгалтаар үнэхээр Эрүүл мэндийн даатгалын сан гэж нэг ёроолгүй авдар, ёроолгүй сав байдагтай адилхан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, түүнийг удирддаг, тэр сангийн менежментийг захиран зарцуулдаг албан тушаалтнууд үнэхээр хариуцлагагүй хайнга, цаашлаад санаатай завших үйлдлүүд хийсэн нь, хийгдэж байсан нь тогтоогдсон.

Үүнд жирийн ажиллаж байгаа эмч нар, эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагч нар буруугүй ээ. Буруу байхгүй. Үүнд үйлчлүүлж байгаа, эмнэлэгт хэвтэж байгаа, эмнэлгээс эмийн хөнгөлөлт авч байгаа, эмийн сангаар үйлчлүүлж иргэд буруутай биш. Үүнийг юуны өмнө хэлмээр байгаа юм.

Ганцхан энэ төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, ард түмэн, татвар төлөгчдийн мөнгийг зөв зарцуулах үүрэг хүлээсэн удирдах албан тушаалтнууд, үүнтэй хуйвалдсан тэр эмнэлгийн удирдлагууд, тодорхой албан тушаалтнууд үнэхээр харамсалтай үйлдлүүд хийсэн байгаа юм. Тэгээд энэ бүхэн бас тогтоогдсон.

- Эрүүл мэндийн даатгалын сангаас нийтдээ –
 - ➔ 550 орчим удаагийн завших оролдлого хийгдсэн байна.
 - ➔ 185 удаагийн хуурамч нэхэмжлэл ирүүлсэн байна.

Завших оролдлогоос үзэх юм бол тодорхой эмнэлгүүд, улсын эмнэлгүүд дээр, хувийн эмнэлгүүд дээр гарч ирж байна. Хуурамч нэхэмжлэхүүд ярих юм бол 340 удаагийн үйлдэлтэй, 42 удаагийн үйлдэлтэй, 40 удаагийн үйлдэлтэй гээд Эрүүл мэндийн даатгалын сангаас мөнгө завших гэсэн хуурамч нэхэмжлэл авсан ийм олон үйлдлүүд баримтаар тогтоогдож байгаа.

Олон удаа Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэгт хэвтэж эмчилгээ авсан иргэд ч гэсэн тоо баримтаар гарч ирж байгаа. Энэ бүгдийг л бид цэгцэлмээр байна. Үүнийг цэгцэлж чадах юм бол энэ ёроолгүй авдар маань ёроолтой болно. Энэ гоожиж байгаа онгорхой сав маань гоожихоо болино. Үүнээс завшиж байгаа, хулгай хийж байгаа, хамаагүй зарцуулж байгаа байдлыг цэгцэлснээрээ эргээд даатгалын сангаас хэмнэгдсэн хөрөнгөөр эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин, эмч нарынхаа цалинг нэмэгдүүлэх боломж бололцоо гарна гэж үзэж байгаа. Энэ дээр ажлын хэсэг гарсан. Тодорхой тооцоо судалгаанууд хийгдэж байна. Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн ажиллаж байна.

Сая 15 хувиар буюу 191.0 тэрбум төгрөгөөр эрүүл мэндийн ажилтнуудын цалинг нэмэхээр тооцсон байгаа. Энэ дээр нэмээд 2.2 их наядын зарлагатай Эрүүл мэндийн даатгалын сангаас 10 хувь хэмнэхэд 220.0 тэрбум болно. Үүгээрээ дахиад эмч нарын цалинг нэмэгдүүлэх бололцоо боломж гарах байх. Гаргах гээд холбогдох тооцоо судалгаанууд хийгдээд Эрүүл мэндийн сайд болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын холбогдох албан тушаалтнууд ажиллаж байгаа гэдгийг танд хэлье.

Б.Пүрэвдорж: Буланы Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Эрүүл мэндийн салбарын цалинг нь хулгайны мөнгө яасны дараа нэмэгдэл мөнгө чинь шударга бус явдал байна л даа.

Тэгэхээр энэ асуудал дээр бас нэг учиртай хандахгүй бол эм, эмнэлгийн хэрэгсэл нь ер нь дутагдалтай, энэ он дамжсаны өрүүд байгаад байхгүй юу. Үүнийгээ нуудаг байхгүй юу. Өвчнөө нуусан хүн чинь тэгээд үхнэ шүү дээ. Үүнийг яагаад ил тод болгодоггүй юм. Он гарсны дараа л нэг нэгээ нөхөөд явдаг. Үнэхээр цалин хөлс нь хүрдэггүй, тоног төхөөрөмж нь байхгүй. Зарим эм, эмнэлгийн хэрэгсэл нь байхгүй. Эмч нар чинь бараг шоронд явах гэж байна шүү дээ. Энэ дээр ер нь анхаармаар юм билээ. Ил болгож байгаач.

Нөгөө талаар бүтэц, орон тоог нь шинэчлэхгүй бол Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, гурван яам нэгдэж байж эмнэлгийн оронд тохируулсан бүтэц, орон тоог шинэчлэхгүй бол энэ цаашаа явахгүй. Гарын салаагаар мөнгө урсаад байна. Энэ дээр анхаарах шаардлагатай гэж бодож байгаа.

Б.Пүрэвдорж: Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Таны хэлж байгаа саналтай санал нэг байна.

2026 оны төсвийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг 5 дахин нэмэгдүүлсэн байгаа.

Манай Т.Мөнхсайхан гишүүн эмч тэргүүтэй 40-өөд Их Хурлын гишүүд санаачлаад 2027 оныг Монгол Улсын Засгийн газраас “ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ” болгон зарлаж байгаа.

Тийм болохоор эрүүл мэндийн салбартаа Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хурал онцгой анхаарч байгаа.

Байгаа бололцоо боломж, нөөцөө шавхаад эхний ээлжид ямар ч гэсэн 15 хувиар цалин нэмэгдэх шийдвэр гарлаа.

Дээрээс нь 15-аас 20 орчмоор Эрүүл мэндийн даатгалын сангаа цэгцэлснээр цалинг нэмэгдүүлэх бололцоо боломж бүрдэнэ гэж үзэж байгаа. Мөн өөр бусад нөөц бололцоо, эх үүсвэрээр саяын ярьж байгаа эрүүл мэнд, эмнэлгийн салбарын тоног төхөөрөмжүүдийг шийдэх бололцоо, боломж гарна.

Ялангуяа 2027 оныг зарлаж байгаатай холбоотойгоор энэ жилээс эхлээд бид зүгээр суухгүй. Манай эрүүл мэндийн салбарын... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асууя.

Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын санг улсын нэгдсэн төсөв дотор оруулаад тэгээд урсгал зардал гэдэг байдлаар явж ирлээ.

Тэгээд үүнийг та хэд ер нь юу гэж үздэг юм бэ? Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангийн ихэнх хувь чинь үндсэндээ тэр даатгал төлөгчдийн өөрсдийнх нь мөнгө шүү дээ.

Тэгээд үүнийг улсын төсөвтэй холиод одоо ингээд бүр сүүлдээ тэр дотаци болгоод, тэгээд төр дааж байгаа гэдэг нэрийдлийн доор энэ сан чинь учирч байгаа хүндрэлүүд төрөөс их хамааралтай болоод байна. Энэ тал дээр Та бүгд мөнгөний бодлогын Тогтвортой байдлын зөвлөлийн хувьд ямар үнэлэлт дүгнэлт өгдөг юм гэдгийг нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт, эрүүл мэндтэй холбоотой хэлэхэд манай Эрүүл мэндийн даатгалын санг ер нь анхнаас нь яам руу аваачаад өгөхийг би анхнаас нь дэмжиж байгаагүй. Хяналт өгч байгаа мөнгөө өөрөө буцаад нөгөө карманаасаа хийдэг ийм даатгалын тогтолцоо дэлхийд ер нь бараг байхгүй. Одоо сөрөг үр дагаврууд нь гарч эхэлж байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, манайх яасан бэ гэхээр гүйцэтгэлийн санхүүжилт Монгол Улсад хэн хийж чаддаг нь, хэдэн хүн үздэг нь мөнгөө ав гэдэг байдлаар сэтгэл хөөрлөөр шилжилтийг бэлтгэлийг нь сайн хангахгүйгээр хийсэн. Үүнээс болоод яаж байна вэ гэхээр Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний үзүүлж

байгаа тоо жил ирэх тусам даблдаж бараг өсөж байгаа. Энэ юу вэ гэхээр сангийн орж байгаа орлогоосоо илүү их зардал гарч байгаа учраас цаашдаа ч гэсэн 2026, 2027, 2028 онд их хүндрэл авчрах эрсдэлтэйтэй учраас бид шилжилт дээр нь яаралтай арга хэмжээ авахгүй бол болохгүй.

Тэгээд энэ тал дээр яг ямар тооцоолол байна? Энэ нь эргээд төсөвт маш их дарамт, эрсдэлийг үүсгэх эрсдэлтэй байгаа. Энэ тал дээр манай Тогтвортой байдлын зөвлөл харж үзсэн үү?

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хэлж байна. Хулгай, энэ зүйлүүд байгаа гэж. Тийм зүйлүүд байгаа байх. Би бас үндэсний зөвлөл байсны хувьд нэлээн шүүмжилдэг байсан. Манай зарим эмнэлгүүд Үндэсний зөвлөлийн гишүүд очоод санг нь үзье гэхээр үзүүлдэггүй. Нуудаг. Тэгээд иймэрхүү байдал байгаа учраас энэ зүйлийг хянаж шалгах, тэгээд бүгдийг нь хянаж шалгана гэхээр үндсэндээ 2 сая даатгал буюу нэг хүний стор гэхэд бараг 70 хуудас байгаа байхгүй юу. Тэгээд энэ өөрөө эргээд хянахад маш их төвөгтэй. Цахимжуулахгүй бол бараг механик ажил хийгээд барахааргүй асуудал байгаа учраас үүнийг нь далимдуулаад бас буруу зөрүү нэхэмжлэлийн шаардлага өгдөг асуудал байдаг.

Хоёрдугаарх нь, хязгаарлах гээд оролдохоор яадаг вэ гэхээр ойролцоо оношийнх нь юмтай хамааруулж байж өвчтөнүүдээ авдаг бас нэг тийм гаж тогтолцоо руу ороод байгаа юм. Төсвийг нь хязгаарлахын тулд зарим оношнуудыг хязгаарлахаар.

Тэгэхээр үүнтэй холбоотой маш олон засах зүйлүүд байгаа юм гэдгийг хэлмээр байна.

Тэгээд эцэст нь хэлэхэд –

- ▶ төр өөрөө хариуцаж байгаа гээд хүмүүс байна;
- ▶ ахмадууд байна;
- ▶ хүүхдүүд байна;
- ▶ зарим төрийн албан хаагч нар байна.

Үүнийхээ төлөө өгч байгаа мөнгө нь яг ний нуугүй хэлэхэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс 2 хувь гээд үндсэндээ 15 мянган төгрөг нэг хүүхдэд өгөөд, тэр хүүхэд 1 сая 500-аас 15 сая, 20 сая төгрөгийн үйлчилгээ авдаг болоор үндсэндээ энэ сан чинь дийлэхгүй болоод байна. Ахмад мөн ялгаа байхгүй.

Нийт санхүүжилтийн гарч байгаа сангийнх нь 70 хувь нь яг төр хариуцаж байгаа хүмүүс гаргаад байгаа юм.

Тийм учраас магадгүй энэ тал дээр тэр Баялгийн сан байдаг юм уу, тэр хүүхдийн юу гэдэг юм Эрүүл мэндийн сан дээрээ тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэхгүй бол яг одоо орлогоороо зарлагаа нийлж дийлэхгүй болоод байгаа юм.

Энэ тал дээр манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн прогноз, таамаглал хийж үзсэн үү гэдгийг асуумаар байна.

Тэгээд үнэгүй гэдэг байдлаар бид мөнгөтэй байх үед нь хэт сэтгэлийн хөөрлөөр хандсан юм билээ.

Тэгэхээр хамтын төлбөр гэдэг юмыг ядаж 10 сая төгрөгийн хагалгаа хийж байгаа хүн 10 мянган төгрөг ч гэсэн өгдөг ийм юм руу нь орохгүй бол хяналт давхар алдагддаг ийм эрсдэл... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхнөөс асуусан уу? Индрийн 3 дугаар микрофон.

Ж.Дэлгэрсайхан: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан. С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Бид Монгол Улсын төсвийн тухай хууль дээр төсвийн бүтэц дээр яах аргагүй төсвийн дотор Нийгмийн даатгалын сангийн төсөв гэж орсон байдаг. Өнөөдрийн мөрдөж байгаа хүчин төгөлдөр хууль эрх зүйн орчноор ингэж явахаас өөр аргагүй байгаа гэдгийг ойлгох нь зүйтэй. Одоогийн хууль эрх зүйн орчин ийм байна.

Хоёрдугаарт, нь нийгмийн даатгалын өнөөдрийн тогтолцоо, ялангуяа тэтгэврийн даатгалын тогтолцоо нь эв санааны нэгдлийн гэдэг тогтолцоон дээр явж байгаа учраас төвлөрүүлээд буцааж тараадаг.

Дээрээс нь өнөөдөр 1.5 орчим их наядын алдагдалтай бөгөөд улсын төсвөөс санхүүжүүлээд явж байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр бидний төсвийн тогтвортой байдлын өгч байгаа дүгнэлт бол Нийгмийн даатгалын сангийн тогтолцоогоо буюу нийгмийн тэтгэврийн даатгалын тогтолцоогоо өөрчлөх шаардлагатай байна.

Тэгэхгүй бол цаашдаа нийгмийн даатгалын тогтолцоо энэ хэвээрээ явж чадахгүй байна. Хуримтлалын болон хувийн тэтгэврийн сангийн тогтолцоог нэмж бүрдүүлснээрээ төсөв дотор байх эсэхээсээ үл хамаараад энэ сангийн нөхцөл байдал өөрөө эрүүлжинэ гэсэн ийм дүгнэлтийг бид хүргүүлж байгаа гэдгээ хэлмээр байна.

Одоо бол яах аргагүй төсвийн бүрэлдэхүүнд энэ байгаа. Одоогийн хууль эрх зүйн орчныг өөрчлөхгүйгээр энэ асуудлыг бид шийдэх боломжгүй ээ гэж хэлье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Сүхбаатар Эрдэнэбат гишүүн дахиж тодруулъя.

С.Эрдэнэбат: Нийгмийн даатгалын санг алдагдалтай гэж яриад байх нь их буруу байгаа юм.

Өөрөөр хэлбэл **“төр хариуцна”** гээд хэсэг хүмүүсийг огт төлөхгүй гэдэг байдлаар төр хариуцаад, түүнийхээ төлөө өгч байгаа мөнгийг **“алдагдал”** гэж яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр магадгүй үүнийг дотаци гэдэг юм уу, эсвэл төр хариуцаж байгаа иргэдийн даатгалыг бүр тусад нь гаргаад, тэгж тавихгүйгээр нийтэд нь холиод алдагдалтай яваад байна, ингээд байна гэхээр ерөөсөө болж өгөхгүй байгаа юм.

Тийм учраас Та хэд үүнийг аягүй сайн тавихгүй бол гадаад, дотоодод ч гэсэн биднийг юу гэж хардаг вэ гэхээр Монгол Улсын нийгмийн даатгалын сан нь алдагдалтай учраас асар их эрсдэлтэй гэдэг үнэлэлт дүгнэлт өгөөд, тэгээд ийм зүйл яваад байгаа учраас бид бүхэн нэр томьёо, цаашдаа нийгмийн даатгалын шинэчлэлийг хийхэд үнэхээр төр дааж байгаа эсэхээ бүр тусад нь сан болгож байгаад тэр хэмжээндээ л зохицуулахгүй бол улс төрчид сэтгэл хөөрлөөр тэрийг даана, үүнийг даана, үүнийг үнэгүй болгоно гээд байхаар сан чинь уначхаад байгаа шүү гэдгийг би тодруулж хэлье.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Одонтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр энэ сая С.Бямбацогт сайд хэллээ л дээ. Байгаа үр дүнг хулгай нүүрлэлээ, үнэхээр аймшигтай болжээ гэж байна. Энэ чинь үр дүн нь байхгүй юу.

Шалтгаан нь юу байсан юм бэ гэхээр ерөөсөө улс төрийн шалтгаантай.

2012-2016 онд миний бие одоо энэ намуудыг оролцуулаад олон улсын байгууллагатай хамтраад бид маш зөв тогтолцоотой Эрүүл мэндийн даатгалын хуулийг баталсан байхгүй юу.

Гэтэл 2016 онд Монгол Ардын нам олонх болонгуутаа зөв байсан тогтолцоог буруу болгоод, Эрүүл мэндийн яамны харьяанд өгснөөс энэ бүх асуудал чинь үүссэн юм. Та нар ЖДҮ сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан гээд маш олон санг тоноод дуусгасан шүү дээ. Одоо Эрүүл мэндийн даатгалын сангаа дуусгах гэж байна л даа.

Тийм учраас би өчигдөр Улсын Их Хурлын тогтоолын төсөл өргөн барьсан байгаа. Ямар тогтоолын төсөл вэ гэхээр Эрүүл мэндийн даатгалын газрыг яаралтай Эрүүл мэндийн яамны харьяаллаас гаргах тогтоолын төсөл байгаа. Энэ болохоор төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчинд өөрчлөлт оруулдаг юм байна.

Тийм учраас үүнийг санаачилсан байгаа. Түүнээс чинь болоод энэ сонгууль дөхсөн хоосон амлалтууд, сонгуулийн шоу, энэ хулгай, энэ хуйвалдаан, энэ бүх юм чинь эхэлж байгаа байхгүй юу.

Эрүүл мэндийн яаманд байж ерөөсөө болохгүй. Яагаад гэхээр Эрүүл мэндийн яам чинь өөрөө чанартай тусламж, үйлчилгээг худалддаг газар болохоос худалдагчдаа аваачаад бүх мөнгөө өгдөг тийм тэнэг хүн гэж хаана байдаг юм.

Бусад оронд Эрүүл мэндийн яамны харьяанд байдаг газар байна. Гэхдээ тэр нь дандаа хувийн эмнэлгүүд зонхилсон газруудад байдаг. Зарим газруудад Нийгмийн хамгааллын яамных нь доор байна.

Тэгэхээр үүнийг яаралтай Эрүүл мэндийн яамнаас салгаж Эрүүл мэндийн даатгал төлөгчдийн мөнгийг хамгаалалтдаа авах шаардлагатай байна. Ингэж даатгал төлөгчдийн мөнгөөр төсвийн цоорхойг нөхөх, өөрсдийнхөө хулгай сонгуулийн шонд ашиглаж болохгүй. Энэ чинь маш том гэмт хэрэг шүү. Өнөөдөр ийм байдалд хүрсэн байна.

Тийм учраас үүнийг бид яаралтай өөрчлөх ёстой.

Дээрээс нь энэ газар бие дааж хаана чанартай тусламж, үйлчилгээ байна тэрийг худалдан авдаг нэг худалдан авагчийн тогтолцоонд яаралтай орох ёстой юм. Үүнийг чинь маш олон удаа олон улсын байгууллагууд, дотоодын төрийн бус байгууллагууд бид ажиллаад шийдсэн байсан шүү дээ.

Дээрээс нь Эрүүл мэндийн сайд нь өөрийн баталсан дүрэм, журам, заавруудыг Үндэсний зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлж шийдвэр гаргадаг нь маш том эрх зүйн зөрчил шүү. Энэ бол ашиг сонирхлын зөрчил. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга нь Эрүүл мэндийн сайд байгаа. Энэ бол хэзээ ч байж болохгүй зүйл.

Тийм учраас энэ тогтоолын төслийг Улсын Их Хурлаар батлуулж хэлэлцүүлэх талаар бид ажиллана гэж бодож байна.

Тэгээд энэ хулгай дээрэм, энэ асуудлаа ер нь тогтолцоог нь өөрчилж байж л шийдэх байх даа. С.Бямбацогт дарга аа. Яагаад гэхээр бусад оронд хяналтыг хийдэг маш том байгууллага байдаг. Гэтэл өнөөдөр хяналтыг нь яам нь өөрөө хийгээд тэндээсээ авлигалаа аваад байж болохгүй ээ.

Тийм учраас энэ маш том асуудал шүү гэдгийг бас дахин дахин хэлье.

Б.Пүрэвдорж: Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Тийм. С.Одонтуяа гишүүнтэй санал нэг байна.

Эрүүл мэндийн байгууллагуудыг гүйцэтгэлээр нь санхүүжүүлдэг болсон юм билээ. 2020 оны үед. Гүйцэтгэлээр нь санхүүжүүлдэг болсон нь бодлого нь зөв. Хэн чанартай эмчилгээ, үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэн хүргэнэ тэр эмнэлэг, тэр эмч илүү өндөр орлоготой, илүү өндөр санхүүжилттэй байх. Чанартай эмчилгээнд, мэдлэгтэй чадвартай эмчид сайн цалин, сайн санхүүжилт очих ёстой гэдэг бодлого нь зөв.

Ганцхан энэ бодлогоо хийгээд хэрэгжүүлэхдээ, зохион байгуулахдаа маш том алдаанууд гаргаад, дээрээс нь хяналтаа тавьж чадаагүй. Хяналтаа тавьж чадаагүй. Тэнд сайн ажиллаж байгаа сайн эмнэлгийн удирдлагын буруу биш, сайн эмчийн буруу биш. Ганцхан энд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар гээд энэ салбарыг удирдаж зохион байгуулж байгаа удирдах албан тушаалтнуудын хариуцлагагүй үйл ажиллагаанаас болоод даатгалын сан маань ийм байдалд орсон байна. Ийм байдалд орсон байна. Үүнийг ойлгож байгаа. Шалгалтаар ер нь тогтоогдож байгаа.

Нэг карманаас аваад нөгөө кармандаа хийдэг. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар эмнэлгүүдтэй гэрээ хийхдээ ямар үнэтэй юмыг ямар үнээр хийх вэ, ямар бүтээгдэхүүн үйлчилгээг ямар тоо хэмжээтэй нийлүүлэх вэ гэдэг дээр тоо хэмжээ, үйлчилгээ ерөөсөө заадаггүй. Ерөнхий гэрээ хийдэг. Хамгийн ашигтай, хамгийн үнэтэй үйлчилгээнүүдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлээ гэж санхүүжилт нэхдэг. Тэр санхүүжилтийг нь нэхэмжлэх ирүүлэхээр нь нэхэмжилсэн үнийн дүнгээс нь илүү санхүүжүүлээд явуулдаг. Ийм л Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байж. Үүнд нь хяналт тавьдаг Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь ажилладаггүй.

Тийм болохоор цаашдаа Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг Эрүүл мэндийн яамнаас хамааралгүй болох ёстой юм билээ. Хараат бусаар бие даасан байдлаар ажиллах бололцоог бүрдүүлж өгч байж үнэхээр сайн бүтээгдэхүүн, сайн эмчилгээ, сайн эмчид сайн санхүүжилт өгдөг.

Эмчилгээ хийхгүй бол хуурамч ямар нэгэн завших оролдлогуудыг таслан зогсоогоод чанартай үйлчилгээнд л хангалттай санхүүжилт өгдөг болох ёстой юм билээ. Үүнийг хийж чадаагүй нь маш том. Өөрөөр хэлэх юм бол бодлого нь зөв байсан. Бодлогоо төлөвлөж, зохион байгуулж, хэрэгжүүлэхдээ хариуцлагагүй хандсан. Эргээд араас нь хяналт тавиагүй. Энэ маань үндсэндээ даатгалын сангаас маш их хэмжээгээр хулгай хийх, завших нөхцөл бололцоог бүрдүүлсэн байна. Нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Тийм болохоор өнөөдөр Эрүүл мэндийн даатгалын сан урьд нь ашигтай байдаг байсан бол, үлдэгдэлтэй байдаг байсан бол одоо дандаа алдагдалтай, 200, 300 тэрбумаар төсвөөс санхүүжүүлдэг болсон.

Эргээд үр ашиггүй зардал нь газар авч хавтгайрсан. Үүнийг цэгцлэх юм бол үүнээс тодорхой хэмжээний эх үүсвэр бий болно. Үүгээр нь эргүүлээд эмч,

эмнэлгийн ажилтнуудынхээ цалин урамшууллыг нэмэгдүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүргэх, тоног төхөөрөмжийг сайжруулах... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сангийн энэ асуудал Ардчилсан намын үед, 2017 оны үед, Тийм ээ. Үгүй ээ. 2014 оны үед энэ хууль гараад нэлээн зөв зүйтэй болсон.

Тэгээд 2016 оноос хойш бараг 2020 он хүртэл Эрүүл мэндийн даатгалын сангийн даргаар Улсын Их Хурлын дарга асан Дамдины Дэмбэрэл гуай ажиллаж Эрүүл мэндийн даатгалын санг илүү ашигтай ажиллуулдаг, сан хөмрөгийг нь нэмэгдүүлдэг ажлыг маш их хийж байсан.

Тэгээд үүнийг нь Ч.Хүрэлбаатар сайд ямар бодлого гаргаж ирсэн бэ гэхээр Эрүүл мэндийн даатгалын “тухайн жилдээ төлсөн төлбөрийг тухайн жилдээ зарцуулаад дуусгана” гэдэг зарчим гаргаад, Д.Дэмбэрэл гуайг явуулж байгаад тэгээд ард нь ийм замбараагүй, саяын хэлдэг 383 мянган ширхэг хуурамч тайлан гаргаад. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын санг тонох зүйл явсан байна.

Тэгэхээр ер нь төрд сайхан уламжлалтай ахмад хүмүүс төрийн сан хөрөнгийг нэмэгдүүлэх талаар сайн ажилладаг юм байна гэдэг нь Д.Дэмбэрэл даргаас илүү харагдсан.

Одоо тэгээд сүүлийн үеийн Эрүүл мэндийн даатгалын сангийн захирлууд чинь бүгдээрээ зүгээр л ерөөсөө хэн гишүүн, ямар сайд үг хэлнэ вэ түүнийх нь дагуу янз янзын замбараагүй зардал гаргасаар байгаад ийм л байдалд оруулж байгаа гэдгийг хэлье.

Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууж үг хэлнэ.

Д.Ганмаа: Би хоёр асуулт асууя гэж бодож байсан.

Тэгэхдээ сая С.Одонтуяа гишүүний асуусан асуулт, тэгээд С.Бямбацогт сайдын хариулт, Б.Пүрэвдорж даргын ярианаас хэдэн юм нэмээд тодруулъя гээд бодлоо л доо.

Эмч, эмнэлгийн ажилчид, эмнэлгийнхэнтэй уулзаад явж байхад хулгай зэлгийний талаар маш их ярьж, надаас асууж байгаа. Бид хулгай хийгээгүй ээ. Хэн хулгай хийсэн юм бэ гэдэг асуудал.

Тэгэхээр үүнийг ер нь би энд асуучихъя. Парламентад.

Шалгалт оруулсан байна. Тийм ээ. Зөрчил илрүүлсэн байна. Хулгай, луйврын талаар маш их асууж байна. Зарим нэгэн хүн шалгагдаж байгаа. Яах вэ, нэрээр нь би мэдэж байгаа.

Хэрвээ сайд нар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга нар хулгайлсан гэж байгаа бол ерөнхийд нь биш нэр заагаад хэлэх боломж байна уу? Хэн хэн сайд юм? Бодвол одоогийн сайд биш байлгүй. Шалгуулж байгаа юм чинь. Т.Мөнхсайхан сайдыг ярьж байна уу? Тэрний өмнөх сайдыг ярьж байна уу? Тэдгээрийн бүр өмнөхийг яриад байна уу?

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар С.Энхболд дарга байсан. Тэрний өмнөх даргууд. Нэг дарга нь л лав шалгагдаж байгаа. Тэрний өмнөх нь яг нэртэй устай. Нэгэнт одоо энд олон жил сонгогдоод, туршлагатай юм чинь нэртэй устай.

Ер нь хүнтэй нь ярьж баймаар байна. Эзэн биетэй нь. Тэгэхгүй бол нэр бүхий юм уу, гишүүд юм уу, нийтээрээ бөөнөөрөө хулгайчид гэж ярихаар жинхэнэ хулгайчид нь завшаад, хулгай хийдэггүйнүүд нь дагаж чирэгдээд дагаад аягүй эмзэглэж байгаа. Миний хувьд.

Уг нь миний асуулт ийм хоёр асуулт асуух гэсэн юм. Цаг маань байвал.

- **Нэгдүгээрт**, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дээр Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцэл хасах гараад байгаа нь 2024 онд олгох тусламж, үйлчилгээний санхүүжилт 1.9 их наяд төгрөг. 2025 онд 1.7 байж төлөвлөж байснаа төсвийн тодотголоор 1.6 болсон. Зардлаа тооцоолохдоо 1.9 их наяд байгаа учраас яг зөрүүг нь тооцохоор 248.0 тэрбум төгрөг болоод байгаа юм.

Гэтэл одоо гараад байгаа зардлууд буюу сая 2026 онд 394.0 тэрбум төгрөгийг нэмэгдсэн зөрүү гаргасан ч гэсэн саяын зөрүү 248.0 тэрбумыг хасахаар 146.0 тэрбум л үлдэх юм.

Энэ нэмэгдэл нь анхан шатдаа орох юм уу? Лавлагаа шатынхаа тусламж, үйлчилгээнд орж байгаа юм уу? Хаана нь төлөвлөсөн байгаа вэ?

- **Хоёрдугаарт**, Хавдар судлалын үндэсний төв 2-ыг барих гээд энэ ажлын хэсэгт ороод дэмжээд явуулсан юм. Тэгэхдээ энд ажиллах хүмүүсийн тоо нь 1500 эмч, ажилтан, туслах ажилчин гэж гарсан байгаа. Тооцоо нь.

Тэгэхээр эдгээр хүмүүс нь төрийн үйлчилгээний албан хаагчид байх уу? Ийм хэмжээний орон тоонд хамаарах цалин, хөлсний тооцооллыг нь хийж үзсэн үү? Тийм бол энэ Эрүүл мэндийн даатгалын сан дээр ямар ачаалал өгөх гэдэг дээр тооцоо судалгаа нь байгаа юу?

Тэгээд ер нь Эрүүл мэндийн даатгалын сан дээр ямар үр нөлөө үзүүлэх юм гэдэг ийм тооцооллыг хийгээд явсан уу, үгүй юу гэдгийг асуулт болгоод асууя.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Сандагийн Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Бид уг нь төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа л даа.

2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн хүрээний төсөөллийг хэлэлцэж байгаа.

Энэ дээр макро эдийн засгийн хэдэн тоонууд л ярих ёстой.

- Монгол Улсын төсвийн орлого ямар байх ёстой вэ.
- Зарлага ямар байх ёстой вэ.
- Төсвийн алдагдал хэд байх юм.
- Инфляц ямар байх юм.
- Дотоодын нийт бүтээгдүүний өсөлт хэд байх юм.

Гэтэл одоо ингээд Эрүүл мэндийн даатгалын сангийн шалгалт болоод явчих юм.

Тийм болохоор энэ асуултад хариулмааргүй байна. Шалгалт.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуултад хариулъя.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг.

Д.Ганмаа гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганмаа: Өмнөх гишүүдийн асуусан асуулт дээр л би уг нь нэмэлтээр асуусан юм. Та хариулаад байсан учраас хариулах болов уу гэсэн үндэслэлээр.

Төсвийн хүрээний мэдэгдлийг яг үнэндээ бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Хавар өгөөд, төсийн хүрээнийхээ мэдэгдлээ баталсан юм. Тэгж ярих юм бол төсвийн хүрээнийхийг одоо ч яриад сууж байх ёсгүй юм.

Б.Пүрэвдорж: Зөв байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо Байнгын хороодоос бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 2 санал байна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд “31,600.0 тэрбум төгрөг” гэснийг “31,930.0 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь 2026 онд “30.9” гэснийг “31.2” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл “-1,380.0 тэрбум төгрөг” гэснийг “1,050.0 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь 2026 онд “-1.3” гэснийг “-1.0” гэж, Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 2026 онд “29.552.0 тэрбум төгрөг” гэснийг “29,859.1 тэрбум төгрөг” гэж, ДНБ-д эзлэх хувь “28.9” гэснийг “29.2” гэж, Нэгдсэн төсвийн суурь тэнцэл “2,048.0 тэрбум төгрөг” гэснийг “2,070.9 тэрбум төгрөг” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Р.Сэддорж.

Санал гаргасан гишүүд саналтайгаа холбоотой үг хэлж болно. Алга байна.
/алх цохив/

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

93 гишүүнээс 61 гишүүн дэмжиж, 65.6 хувиар дэмжлээ. Мөн Да.Цогтбаатар гишүүн дэмжсэнээр тооцъё. Протоколд тэмдэглээ.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд “31,600.0 тэрбум төгрөг” гэснийг “490.0 тэрбум төгрөг”-өөр, Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2026 онд “32,980.0 тэрбум төгрөг” гэснийг “490.0 тэрбум төгрөг”-өөр тус тус нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан холбогдох эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон харгалзах ДНБ-д эзлэх хувьд өөрчлөлт оруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Саналтайгаа холбоотой Ц.Мөнхтуяа гишүүн үг хэлж болно. Үг хэлэхгүй юм байна.

Хүний хөгжилд нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

93 гишүүнээс 53 гишүүн дэмжиж, 57.0 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 50 минут үргэлжилж, 14 цаг 58 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД